



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 4/92

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/173, А/193 дугаар тушаалууд, Удирдлагын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аюултай хог хаягдлыг зохицуулах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг Албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биоүйлдвэрлэл ариутгал, халдваргүйтгэлийн албаны дарга (Ц.Хишигжаргал)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төвийн ерөнхий захирлын 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР



10/12

പേര്: ധർമ്മദാസ് നമ്പ്യാ

12345678910111213141516171819202122232425262728293031323334353637383940414243444546474849505152535455565758596061626364656667686970717273747576777879808182838485868788899091929394959697989910010110210310410510610710810911011111211311411511611711811912012112212312412512612712812913013113213313413513613713813914014114214314414514614714814915015115215315415515615715815916016116216316416516616716816917017117217317417517617717817918018118218318418518618718818919019119219319419519619719819920020120220320420520620720820921021121221321421521621721821922022122222322422522622722822923023123223323423523623723823924024124224324424524624724824925025125225325425525625725825926026126226326426526626726826927027127227327427527627727827928028128228328428528628728828929029129229329429529629729829930030130230330430530630730830931031131231331431531631731831932032132232332432532632732832933033133233333433533633733833934034134234334434534634734834935035135235335435535635735835936036136236336436536636736836937037137237337437537637737837938038138238338438538638738838939039139239339439539639739839940040140240340440540640740840941041141241341441541641741841942042142242342442542642742842943043143243343443543643743843944044144244344444544644744844945045145245345445545645745845946046146246346446546646746846947047147247347447547647747847948048148248348448548648748848949049149249349449549649749849950050150250350450550650750850951051151251351451551651751851952052152252352452552652752852953053153253353453553653753853954054154254354454554654754854955055155255355455555655755855956056156256356456556656756856957057157257357457557657757857958058158258358458558658758858959059159259359459559659759859960060160260360460560660760860961061161261361461561661761861962062162262362462562662762862963063163263363463563663763863964064164264364464564664764864965065165265365465565665765865966066166266366466566666766866967067167267367467567667767867968068168268368468568668768868969069169269369469569669769869970070170270370470570670770870971071171271371471571671771871972072172272372472572672772872973073173273373473573673773873974074174274374474574674774874975075175275375475575675775875976076176276376476576676776876977077177277377477577677777877978078178278378478578678778878979079179279379479579679779879980080180280380480580680780880981081181281381481581681781881982082182282382482582682782882983083183283383483583683783883984084184284384484584684784884985085185285385485585685785885986086186286386486586686786886987087187287387487587687787887988088188288388488588688788888989089189289389489589689789889990090190290390490590690790890991091191291391491591691791891992092192292392492592692792892993093193293393493593693793893994094194294394494594694794894995095195295395495595695795895996096196296396496596696796896997097197297397497597697797897998098198298398498598698798898999099199299399499599699799899910001001100210031004100510061007100810091010101110121013101410151016101710181019102010211022102310241025102610271028102910301031103210331034103510361037103810391040104110421043104410451046104710481049105010511052105310541055105610571058105910601061106210631064106510661067106810691070107110721073107410751076107710781079108010811082108310841085108610871088108910901091109210931094109510961097109810991100110111021103110411051106110711081109111011111112111311141115111611171118111911201121112211231124112511261127112811291130113111321133113411351136113711381139114011411142114311441145114611471148114911501151115211531154115511561157115811591160116111621163116411651166116711681169117011711172117311741175117611771178117911801181118211831184118511861187118811891190119111921193119411951196119711981199120012011202120312041205120612071208120912101211121212131214121512161217121812191220122112221223122412251226122712281229123012311232123312341235123612371238123912401241124212431244124512461247124812491250125112521253125412551256125712581259126012611262126312641265126612671268126912701271127212731274127512761277127812791280128112821283128412851286128712881289129012911292129312941295129612971298129913001

[illegible]

10. *Staphylococcus aureus* (Staph aureus)

[illegible][illegible][illegible][illegible]

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны ..12.. дугаар сарын ...30...-ны өдрийн
...12/30... дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

УЛААНБААТАР ХОТ
2025

Агуулга

Нэг. Үндэслэл	3
Хоёр. Зорилго	3
Гурав. Нэр томъёо	3
Дөрөв. Хамрах хүрээ	5
Тав. Хог хаягдлын ангилал	5
5.1 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал	5
5.2 Энгийн хог хаягдал	6
5.2.1 Ахуйн хог хаягдал	6
5.2.2 Дахивар нөөц хог хаягдал	6
5.3 Аюултай хог хаягдал	7
5.3.1 Халдвартай хог хаягдал	7
5.3.2 Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал	8
5.3.3 Эмгэг хог хаягдал	9
5.3.4 Эмийн болон эсэд хортой хог хаягдал	9
5.3.6. Цацраг идэвхт хаягдал	11
Зургаа. Аюултай хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх, халдваргүйжүүлэх, түр хадгалах, устгах үйл ажиллагаа	12
6.1 Аюултай хог хаягдлыг цуглуулах	12
6.2 Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх	12
6.3 Хог хаягдлыг халдваргүйжүүлэх	12
6.4 Аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах	14
6.5 Үйл ажиллагааны зураглал	14
ДОЛОО. Албаны дарга, эмч, ажилтнуудын үүрэг, хариуцлага	14
7.1 Албаны даргын үүрэг	14
7.2 Ариутгагч, бэлдмэлчин нарын үүрэг	15
7.4 Халдвар судлагч эмчийн үүрэг	15
7.5 Эмч, ажилтан, лаборант нарын үүрэг	16
7.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын эм зүйч, тооцооны нягтлан бодогч нарын үүрэг	16
НАЙМ. Хариуцлага	17
ХАВСРАЛТ	Error! Bookmark not defined.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/173 “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах ” , А/193 “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах” заавруудыг тус тус үндэслэн журмыг шинэчлэн боловсруулав.

Хоёр. Зорилго

Зоонозын өвчний тусламж, үйлчилгээтэй холбогдолтой гарсан аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, халдваргүйжүүлэх, түр хадгалах, актлах, устгах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Гурав. Нэр томьёо

- 3.1. "Хог хаягдал" гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;
- 3.2. "Энгийн хог хаягдал" гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;
- 3.3. "Ахуйн хог хаягдал" гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг;
- 3.4. "Дахивар нөөц" гэж дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг;
- 3.5. "Аюултай хог хаягдал" гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;
- 3.6. "Хог хаягдал ангилах" гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг;
- 3.7. "Хог хаягдал цуглуулах" гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг;
- 3.8. "Хог хаягдал хадгалах" гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулахыг;
- 3.9. "Хог хаягдлыг шатаах" гэж хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж, задлахыг;
- 3.10. "Хог хаягдлыг булшлах" гэж хог хаягдлыг газарт булж хадгалахыг;
- 3.11. "Биологийн боловсруулалт" гэж бичил биетээр бохирдуулагчийг устгах болон хоргүйжүүлэхийг;
- 3.12. "Хими-физикийн боловсруулалт" гэж химийн болон физикийн боловсруулалтыг хослуулан хэрэглэхийг;
- 3.13. "Химийн боловсруулалт" гэж химийн бодис ашиглаж хоргүйжүүлэхийг;
- 3.14. "Физикийн боловсруулалт" гэж шүүх, тунадасжуулах, шингээх, нэрэх зэрэг аргаар бохирдуулагчийг цэвэрлэхийг;

3.15. "Халдваргүйжүүлэх" гэж химийн болон физикийн аргаар халдвартай бичил биетийг устгахыг;

3.16. "Хог хаягдлыг устгах" гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг;

3.17. "Хог хаягдал шатаах зориулалтын байгууламж" гэж хог хаягдлыг өндөр хэмд, хяналттай шатаах төхөөрөмж бүхий байгууламжийг;

3.18. "Ландфилл" гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг;

3.19. "Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах" гэж хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой бүтээгдэхүүн импортлох, хэрэглэх болон хог хаягдалгүй эсхүл хамгийн бага хэмжээгээр үүсгэдэг технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;

3.20. "Аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс" гэж аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, хадгалах, устгахад шаардагдах зардлын мөнгөн дүнг;

3.21. "Хог хаягдлын төвлөрсөн цэг" гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газрыг;

3.22. "Аюултай хог хаягдал үүсгэгч" гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;

3.23. "Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан" гэж хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажилтныг;

3.24. "Эм" гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зориулалттай, хүний физиологийн үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдэл нь эм судлал, эмнэлзүйн туршилтаар нотлогдсон, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг, тодорхой хэлбэртэй бүтээгдэхүүнийг;

3.25. "Вакцин" гэж хүний биед халдварт өвчний эсрэг өвөрмөц дархлал бий болгох биобэлдмэлийг;

3.26. "Лабораторийн оношилгооны хэрэгсэл" гэж хүн, амьтны биеэс авсан сорьцыг ашиглан өвчин эмгэгийг оношлох, эмчилгээний хяналт хийх, баталгаажуулах, биобэлдмэлд халдвар илрүүлэх зориулалттай дангаар болон бусад хэрэгсэлтэй хослуулан ашиглах эмнэлгийн хэрэгслийг;

3.27. "Эмнэлгийн тоног төхөөрөмж" гэж өвчин эмгэг, гэмтэл согогийг оношлох, эмчлэх, хянах, сэргээн засах, эмнэлгийн хэрэгслийг ариутгах, халдваргүйжүүлэх зориулалттай, дангаар болон бусад хэрэгсэлтэй хослуулан ашиглах эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийн мэргэжлийн үйл ажиллагаа шаардагдах эмнэлгийн хэрэгслийг;

3.28. "Эмнэлгийн хэрэглэгдэхүүн" гэж өвчин эмгэг, гэмтэл согогийг оношлох, эмчлэх, хянах, нөхөн сэргээх, сэргээн засах, сувилах, хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагааг хамгаалах, эд эрхтнийг хиймлээр орлуулах, хүний гадаад төрх байдлыг өөрчлөхөд хэрэглэх зориулалттай нэг удаагийн болон дахин ашиглах боломжтой эмнэлгийн хэрэгслийг;

3.29. "Хугацаа дууссан эм" гэж сав баглаа боодол дээрх үйлдвэрлэгчийн заасан хадгалалтын хугацаа дууссан эм;

3.30. "Цуврал" гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эм, биобэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн багцыг;

3.31. "Хуурамч эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн" гэж гарал үүсэл, гадна байдал, найрлага, хэлбэр, шошго, цувралыг хууль бусаар дуурайлган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;

3.32. "Эмчилгээний идэвх" гэж эмийг зах зээлд гаргасны дараа лабораторийн болон эмнэлзүйн туршилт судалгаагаар нотлогдсон, хүний бие махбодод үзүүлж байгаа нөлөөг;

3.33. "Эмийн үйлчлэгч бодис" гэж хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдэл үзүүлдэг байгалийн болон химийн гаралтай дан, эсхүл нийлмэл бодисыг;

3.34. "Стандартын бус эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн" гэж фармакопей, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг;

3.35. "Эмийн гаж нөлөө" гэж өвчнийг эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэх зорилгоор эмийг эмчилгээний тунгаар хэрэглэхэд илэрч байгаа хүсээгүй сөрөг илрэлийг;

Дөрөв. Хамрах хүрээ


4.1 Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ), нийслэл, аймгийн зоонозын өвчин судлах төвүүд (ЗӨСТ) энэхүү журмыг хэрэгжүүлнэ.

Тав. Хог хаягдлын ангилал

5.1 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал

Эрүүл мэндийн байгууллагаас үүсч буй нийт хог хаягдлыг энгийн болон аюултай гэж 2 ангилна. (Бүдүүвч 1)

Бүдүүвч 1: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал



5.2 Энгийн хог хаягдал

Энгийн хог хаягдлыг ахуйн, дахивар нөөц хог хаягдал гэж 2 ангилна.

5.2.1 Ахуйн хог хаягдал

Байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуур, эм урвалжийн гадна талын сав, баглаа боодол, зүүний хуванцар таглаа, хоол хүнсний үлдэгдэл зэрэг аюултай хог хаягдалд хамаарахгүй хаягдлууд орно. (Хүснэгт 1А.)

Хүснэгт 1А. Ахуйн хог хаягдал

Өнгө	ХАР
Таних тэмдэг	Тэмдэглэгээ, таних тэмдэг шаардлагагүй
Цуглуулах	Хар өнгийн нийлэг уутанд хийнэ.
Хаяглалт	Шаардлагагүй
Устгал:	Тухайн орон нутгийн хог хаягдал хариуцсан тохижилт үйлчилгээний байгууллагад хүлээлгэн өгнө.

5.2.2 Дахивар нөөц хог хаягдал

Шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр, хуванцар, антибиотик, физиологийн уусмал зэрэг хоргүй эмийн флакон, болон тарилгын шингэний хуванцар сав, уут хамаарна. (Хүснэгт 1Б.)

Хүснэгт 1Б. Дахивар нөөц хог хаягдал

Өнгө	ӨНГӨГҮЙ	
Таних тэмдэг	Цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын олон улсын таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.	
Цуглуулах	Өнгөгүй нийлэг уут болон таних тэмдэг бүхий бусад төрлийн саванд хийнэ.	
Хаяглалт	Лааз-шил, хуванцар, цаас гэх мэт	
Устгал	Хог хаягдал дахин боловсруулах байгууллагад хүлээлгэн өгнө.	

5.3 Аюултай хог хаягдал

Аюултай хог хаягдалд халдвартай хог хаягдал, хурц үзүүртэй, иртэй хог хаягдал, эмгэг хог хаягдал, эмийн болон эсэд хортой нөлөөтэй хог хаягдал, химийн бодисын хог хаягдал, цацраг идэвхт хог хаягдал хамаарна.

5.3.1 Халдвартай хог хаягдал

Эрүүл мэндийн сайдын 2025 А/173 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтаас гадна дараах халдвартай хог хаягдал багтана.

Гадаад орчноос цуглуулсан (хөрс, бууц, ус, махчин шувууны гулгидас), халдварын сэжигтэй мал амьтны түүхий эд (үс, ноос, арьс шир), халдвар хийсэн туршилтын амьтан, тэдгээрийн эд эрхтэн хоривч, байгалиас цуглуулсан мэрэгч амьтад, тэдгээрийн эд эрхтэн, байгалиас цуглуулсан амьд байгаа эсвэл шинжилгээнд шилжүүлэх хүртэл хадгалах явцад үхсэн ,эсвэл шинжилгээний шаардлага хангахгүй болсон цус сорогч үе хөлтөн, хачиг, бөөс, бүүрэг, шумуул, хөх түрүү, дэлэнч Microbank™ , орчны суулгацууд гэх мэт хог хаягдал хамаарна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Халдвартай хог хаягдал

Өнгө	Шар	
Таних тэмдэг	“Био аюултай” таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.	
Цуглуулах	- Шингэн нэвчдэггүй, бат бөх, халуунд тэсвэртэй шар өнгийн уутанд хийнэ - Хогийн савны $\frac{3}{4}$ хэмжээнээс хэтрүүлэлгүй хийнэ. - Мэс заслын өрөөний хог хаягдлыг ажилбар бүрийн дараа өрөөнөөс гаргаж түр хадгалах байр руу зөөвөрлөнө.	
Хаяглалт	- Хог хаягдлын уутны гадна талд хаягжилт хийнэ. Үүнд: - Алба, нэгжийн нэр - Огноо	

5.3.2 Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

Наалдацын шил, мэс заслын хутга, ир, хагарсан ампул, пипетка, петрийн аяга, хуруу шил, лабораторийн гогцоо гэх мэт хог хаягдал хамаарна. (Хүснэгт 3.)

Хүснэгт 3. Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

Өнгө	Шар
Таних тэмдэг	Аюулгүй хайрцгийн гадна талд $\frac{3}{4}$ түвшинд “ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО” Гэсэн анхааруулга бүхий хэвтээ шугам хэвлэгдсэн байх шаардлагатай 
Цуглуулах	Шингэн нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зузаан цаасан болон хуванцар зориулалтын “Аюулгүй хайрцаг”-т цуглуулна. Аюулгүйн хайрцгийг суллаж давтан хэрэглэхийг хориглоно. Аюулгүйн хайрцагийг ашиглах явцад хог хаягдлыг хийхээс бусад тохиолдолд тагийг байнга хаалттай байлгана. Тариурын зүүний тагийг эргүүлэн таглахгүй, аюулгүйн хайрцагт хийнэ. Зүү мултлагчгүй аюулгүй хайрцагт (цаасан аюулгүй хайрцаг) тариуруус зүүг салгалгүйгээр хийнэ. Зүү мулталагчтай хуванцар аюулгүй хайрцаг, зүү тайрагч, шатаагч хэрэглэсэн тохиолдолд тариурын ар талын хуванцар хэсгийг шар өнгийн халдвартай хог хаягдлын уутанд хийнэ. Аюулгүйн хайрцгийг $\frac{3}{4}$ хэсгийг дүүрмэгц битүүмжилж түр хадгалах цэг, байр руу зөөвөрлөнө. Нээж ашиглаж эхэлснээс хойш 1 сар болсон бол аюулгүй хайрцаг дүүрсэн эсэхээс үл хамааран түр хадгалах байр руу өгнө. Аюулгүйн хайрцгийг түр хадгалах байр руу зөөвөрлөх хүртэл тасаг нэгж дотор түр хадгалах шаардлагатай бол “Биоаюултай” таних тэмдэг бүхий таглаатай саванд хийж, цоожтой өрөө, эсвэл, хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу газар тусгай цэгт хадгална. Аюулгүйн хайрцгийг ил задгай орхиж болохгүй. Аюулгүйн хайрцгийг түр хадгалах байр хүртэл тагтай, бариултай “Биоаюултай” таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөнө. Энэ төрлийн хог хаягдлыг шахаж нягтруулж болохгүй.
Хаяглалт	Алба, нэгжийн нэр Ашиглаж эхэлсэн огноо

5.3.3 Эмгэг хог хаягдал

Халдвартай болон халдварын сэжигтэй мал, амьтан тэдгээрийн сэг, зэм халдварт өвчний бус шалтгаанаар үрэгдсэн туршилт судалгааны амьтад зэрэг нь эмгэг хог хаягдалд хамаарна. (Хүснэгт 4.)

Хүснэгт 4. Эмгэг хог хаягдал

Өнгө	Шар	
Таних тэмдэг	ЭМГЭГ ХОГ ХАЯГДАЛ БОЛГООМЖТОЙ ХАРЬЦАНА УУ гэсэн анхааруулга савны гадна талд байршуулна. Шингэн нэвчдэггүй бат бөх, халуунд тэсвэртэй шар өнгийн уут бүхий таглаатай саванд цуглуулна.	
Савлах цуглуулах	Уутыг ¾ -аас дээш дүүргэхгүй, Уутыг суллан дахин ашиглаж болохгүй	
Хаяглалт	Алба, нэгжийн нэр Огноо	
Хадгалах	Хөргүүрт бусад төрлийн хог хаягдлаас тусад нь хадгалах. Хөргүүртэй бол 72 цаг, хөргүүргүй бол 24 цагаас илүү хугацаанд хадгалж болохгүй. Шахаж нягтруулж болохгүй.	

5.3.4 Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг зэрэг нь эмийн хог хаягдалд хавдрын эмчилгээний үед хэрэглэдэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хэрэглэсэн зүү, тариур зэрэг нь эсэд хортой эмийн хог хаягдалд хамаарна.(Хавсралт 1 харна уу.) (Хүснэгт 5.)

Хүснэгт 5. Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Өнгө	Хүрэн	
	Эмийн хог хаягдал	Эсэд хортой хог хаягдал
Эрсдэл	Хортой	Эсэд хортой
Савлах цуглуулах	Шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд цуглуулна. Хог хаягдлын маягтын дагуу бүртгэж устгана.	Шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд цуглуулна. Зүү хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг ус нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, хуванцар аюулгүйн хайрцагт цуглуулж, битүүмжилсэний

		дараа шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд хийнэ. Хог хаягдлын маягтын дагуу бүртгэж устгана.
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааран тохирох таних тэмдэгтэй байна.	
Хаяглалт	Алба, нэгжийн нэр Хог хаягдал үүссэн огноо	
Хадгалах	Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй. Энэ төрлийн хог хаягдлыг цуглуулах, савлах, устгах асуудлыг эмнэлэгийн эм зүйн алба баг хариуцна.	

5.3.5. Химийн бодисын хог хаягдал

Лабораторийн хог хаягдал (урвалж, оношлуур, химийн бодисын хаягдал), формальдегид, этилен оксид, хугацаа дууссан химийн бодисууд, Өдрийн гэрэл, зай, цэвэрлэгээ, халдваргүйтгэлд хэрэглэсэн халдваргүйжүүлэх бодис, химийн бодисын сав, уут, химийн бодис жигнэж хэмжсэн цаасан таваг зэрэг хог хаягдал хамаарна. (Хүснэгт 6.)

Хүснэгт 6. Химийн бодисын хог хаягдал

Өнгө	Хүрэн
Эрсдэл	Химийн бодисын төрөл, шинж чанараас хамаарна.
Савлах цуглуулах	Өөр өөр төрлийн химийн бодисын хог хаягдлыг хольж болохгүй. Химийн бодисын үлдэгдлийг цуглуулах савны 50% -иас дүүргэж болохгүй. Шингэн хог хаягдлыг битүүмжлэл бүхий тагтай, түгжээтэй саванд цуглуулах.
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааруулан хортой, зэврэмтгий, исэл, шатамхай, холимог аюултай, хүрээлэн буй орчныг бохирдуулах материал, эсэд хортой г.м тохирох таних тэмдэгтэй байна.
Хаяглалт	Алба, нэгжийн нэр Хог хаягдал үүссэн огноо Хог хаягдлын хэмжээ Химийн бодисын нэр, төрлийг бичнэ
Хадгалах тээвэрлэх	Химийн бодисын төрөл шинж чанараас хамааран хадгалах нөхцөл өөр өөр байна. Химийн бодисын хог хаягдал асгарч болзошгүй тул савыг шингэн цуглуулах тавиур дээр тавина. Хоорондоо урвалд орж болзошгүй химийн бодисын химийн бодисын хог хаягдлыг тусад нь хадгална Зөөх, тээвэрлэх, нөхцлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай саванд хийнэ.

5.3.6. Цацраг идэвхт хаягдал

Цацраг идэвхт хаягдалд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны явцад гарсан цаашид дахин хэрэглэгдэхгүй, цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн ионжуулагч цацраг бүхий цацраг идэвхт изотоп агуулсан, ямарч төлөв байдалд байж болох хаягдал хамаарна. (Хүснэгт 7.)

Хүснэгт 7. Цацраг идэвхт хаягдал

Эрсдэл	Цацраг идэвхт хаягдлыг физик, хими, цацраг, биологийн шинж чанараас нь хамааруулж ангилж, ялгах бөгөөд цацрагийн болон цацрагийн бус эрсдэлийг тооцоолно.	
Савлах цуглуулах	Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм"-д зааснаар цацраг идэвхт хаягдлыг физик, хими, цацраг, биологийн шинж чанараас нь хамааруулж ангилж, ялгах бөгөөд цацрагийн болон цацрагийн бус эрсдэлийг тооцоолж аюулгүй ажиллагааг хангана.	
Таних тэмдэг		Олон улсын цацрагийн таних тэмдэгтэй байна. - 1, 2, 3 дугаар ангиллын үүсгүүр - 4, 5 дугаар ангиллын үүсгүүр Ямар ч тохиолдолд тэмдгийг аюулгүй зайнаас таньж болохоор зургийн харьцааг хадгалсан байх бөгөөд хэмжээ нь түүнийг зүүх буюу наах төхөөрөмж, материалын овор хэмжээтэй зохицуулан хийж, аль болох тод харагдахуйц байрлалд байрлуулж ашиглана. (MNS ISO 361:2001 стандарт)
Хаяглалт	Цацраг идэвхт хаягдлыг "Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм"-д заасны дагуу хаяглана. Хаягдлын контейнерт дараах мэдээллийг тэмдэглэнэ: цацраг идэвхт цөм; хувийн дугаар; цацраг идэвх, огноо.	
Хадгалалт	Цацраг идэвхт хаягдалтай холбоотой үйл ажиллагаанд "Цөмийн энергийн тухай" хууль, "Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм", "Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм" болон холбогдох норм, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана. Цацраг идэвхт шингэн хаягдал тухайлбал эмчилгээний өндөр тунгаар цацраг идэвхт изотопыг хэрэглэсэн өвчтөнүүдээс гарч буй өтгөн, шээс зэрэг биологийн шингэнийг төвлөрсөн бохир усны шугамд хаяхын өмнө хамгаалалттай саванд хяналтаас чөлөөлөх түвшин хүртэл хадгална.	

Зургаа. Аюултай хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх, халдваргүйжүүлэх, түр хадгалах, устгах үйл ажиллагаа

6.1 Аюултай хог хаягдлыг цуглуулах

6.1.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагад нийцсэн хог хаягдал цуглуулах уут, хогийн сав, аюулгүйн хайрцаг хэрэглэнэ. Хогийн уутны “Биоаюултай” таних тэмдгийн доор алба, нэгжийн нэр, уут ашиглаж эхэлсэн цаг, огноог тэмдэглэх хаяглах хэсгийг хэвлэсэн эсвэл арилдаггүй бичгийн хэрэгслээр бичсэн байна.

6.1.2 Хог хаягдал үүсэж байгаа газарт ангилан ялгаж цуглуулах уут, савыг байршуулж, хог хаягдлыг зөв ангилах талаар заавар, санамжийг тавьсан байна.

6.1.3 Хог хаягдлын халдварын эрсдэл өндөртэй тасаг нэгжүүдээс эхлэн өдөрт 1 доошгүй удаа цуглуулна.

6.2 Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх

6.2.1 Ууттай хог хаягдлыг түр хадгалах байр, хүртэл тагтай, бариултай “Биоаюултай” таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөнө.

6.2.2 Ууттай хог хаягдлыг ил задгай орхиж болохгүй.

6.2.3 Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөж болохгүй.

6.2.4 Хог хаягдал ангилан ялгасан цэгээс ариутгагч, бэлдмэлчин нар өглөө бүр 08.30-09.30 цагт цуглуулж хог хаягдлын ажилтанд жинлэн хүлээлгэн өгнө.

6.2.5 Хог хаягдал зөөвөрлөх тэргэнцэр, савыг өдөр бүр ажил дууссаны дараа угааж халдваргүйжүүлнэ.

6.3 Хог хаягдлыг халдваргүйжүүлэх

6.3.1 Хог хаягдлыг халдваргүйжүүлэхдээ **халуун өндөр даралттай уураар, химийн бодисоор** эсвэл **буталж жижиглэн өндөр даралттай уураар** халдваргүйжүүлэх хэсгийн байгууламжийн аль нэгийг ашиглана.

6.3.2 Халдвартай хог хаягдлыг даралтат уурын аргаар халдваргүйжүүлэхдээ халдвар судлагч эмчийн хяналтад ариутгагч болон хог хаягдлын ажилтан гүйцэтгэж анхан шатны бүртгэл маягтад тэмдэглэнэ.

6.3.2.1 Автоклавын ажиллахдаа хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн хэрэглэж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж мэргэжлийн ариутгагч, хог хаягдлын ажилтан ажиллуулна.

6.3.2.2 Хог хаягдлыг автоклавт 121⁰C-ийн хэмд 20 минут, 134⁰C-ийн хэмд 10 минутын хугацаанд халдваргүйжүүлнэ. Давтан хэрэглэх шил савтай халдвартай материалыг үр үүсгэдэг нянгийн халдвартай материал бол 132⁰C-ийн хэмд 90 минут, үр үүсгэдэггүй нянгийн халдвартай материал бол 126⁰C-ийн хэмд 60 минут халдваргүйтгэнэ.

6.3.2.3 Халуун ууранд түлэгдэх, эмтэрсэн шилэнд зүсэгдэх зэрэг эрсдэлтэй тул автоклавын халдваргүйтгэлийн үе шат дуусаж, даралт “Тэг” болсны дараа хаалгыг нээнэ.

6.3.2.4 Хэрэв шингэн асгарсан тохиолдолд автоклавыг гүйцэт хөрсний дараа нэн даруй цэвэрлэнэ.

6.3.2.5 Автоклавын камер дотор шил хагарсан тохиолдолд зориулалтын чимхүүр ашиглан цэвэрлэнэ. Бээлийтэй гараар цэвэрлэж болохгүй.

6.3.2.6 Уусгагч, ууршилттай хлорт нэгдлүүд, (HCL, цайруулах) буюу идэмхий химийн бодисууд (фенол, гурван хлорт цууны хүчил, эфир, хлорформ) эсэд хортой нөлөөтэй хог хаягдал, түүгээр бохирдсон материал, цацраг идэвх материал, зарим хуванцар, хүнд металлын хог хаягдлыг автоклавт хийхийг хориглоно.

6.3.2.7 Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг техникийн буюу физик, хими, биологийн аргаар хянана. Тухай бүрд нь физик, химийн хяналтыг хийж тестийг анхан шатны бүртгэл маягтад наана. Биологийн тестээр сар бүр хянана.

6.3.3 Химийн аргаар халдваргүйжүүлэх

6.3.3.1 Халдвартай хог хаягдлыг химийн аргаар халдваргүйжүүлэх ажиллагааг тухайн сорьц, материалыг шинжилсэн эмч, лаборант хариуцаж Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн халдваргүйжүүлэлтийн бодисыг заавар журмын дагуу хийж огноог тавина.

6.3.3.2 Лабораторийн шинжилгээ дуусаж хариу нь гарсан зарим сорьцууд (хөрс, бууц, ус махчин шувууны гулгидас, мал амьтны түүхий эд, халдвар хийсэн туршилтын амьтад, байгалиас цуглуулсан мэрэгч, амьтад)-ын эх материал болон тэдгээрийг агуулж байсан уут, сав зэргийг халдваргүйжүүлэлтийн уусмалд хийж үр үүсгэдэггүй нян агуулсан бол 24 цаг, үр үүсгэдэг нян агуулсан бол 48 цагийн турш химийн аргаар халдваргүйтгэнэ.

6.3.3.3 Химийн аргаар халдваргүйжүүлсэн хөрс, бууцыг уусмалтай нь хамт, халдвартай бусад хог хаягдлын эх материалыг халдваргүйжүүлсэн уусмалаас шүүж авч шар уутанд хийж аюултай хог хаягдал устгах гэрээний дагуу төвлөрсөн байгууламжид шилжүүлж, уусмалыг саармагжуулан төвлөрсөн бохирын шугамд хийх ажлыг ариутгагч, бэлдмэлчин нар хариуцан гүйцэтгэнэ.

6.3.3.4 Амьтанд халдвар хийсэн зүү тариурыг халдваргүйжүүлэлтийн уусмалд хийж үр үүсгэдэггүй нянтай бол 24 цаг, үр үүсгэдэг нян агуулсан бол 48 цаг халдваргүйжүүлсний дараа корнцангийн тусламжтайгаар уусмалаас гаргаж “Аюулгүйн хайрцагт” хийнэ.

6.3.3.5 Халдваргүйжүүлэлтэд хэрэглэсэн уусмалыг саармагжуулж бохирын шугамд нийлүүлнэ. Хэрэв бохир ус зайлуулах шугамд холбогдоогүй бол хөрс, газрын доорх усыг бохирдуулахгүй эрүүл ахуйн шаардлага хангасан бохирын цооногт хийнэ.

6.3.4 Хэсгийн байгууламжид халдваргүйжүүлэх

6.3.4.1 Хог хаягдлыг буталж, өндөр даралттай халуун уураар халдваргүйжүүлэх горимтой тоног төхөөрөмж ашиглана.

6.3.4.2 Үйлдвэрлэгчийн зааврыг мөрдөн ажиллана. Тохирох хог хаягдлыг боловсруулна. Халдваргүйжүүлж бутлах төхөөрөмжид үйлдвэрлэгчийн зааварт заасан хог хаягдлыг хийнэ.

6.3.4.3 Нэг мөчлөгт халдваргүйжүүлж бутлах хог хаягдлын хэмжээг төхөөрөмжийн хүчин чадалд тохируулан тооцно.

6.3.4.4 Бутлах төхөөрөмжид зузаан ган, титан, металл эд зүйлс, сүлжмэл эдлэл, эмгэг, эмийн болон эсэд хортой, хүнд металл, цацраг идэвхт, химийн бодис зэрэг хог хаягдлыг хийхийг хориглоно.

6.4 Аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах

6.4.1 Аюултай хог хаягдал түр хадгалах байр нь гадны хүн орохооргүй нийтийн хөл хөдөлгөөнөөс зайтай, амьтан орохооргүй, цоожтой байна. Хог хаягдал хүлээн авах, хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах хэсэгтэй байна.

6.4.2 Гар угаах, бохир сав угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.4.3 0.1-120 кг хүртэл жинлэх боломжтой электрон жинтэй байна.

6.4.4 Эмгэг хог хаягдал хадгалах хөргөгчтэй байна.

6.4.5 Гадна талдаа “Биоаюултай” таних тэмдэгтэй, аюултай хог хаягдал түр хадгалах байр гэсэн хаягтай байна.

6.4.6 Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайтай байна.

6.4.7 Хадгалалтын хугацаа дууссан, задалснаас хойш ашиглах боломжгүй болсон үлдэгдэл вакцин, биобэлдмэлийг халдвартай хог хаягдал цуглуулах зориулалтын уут, ампултай вакцины үлдэгдэл ампулыг аюулгүй хайрцагт цуглуулан түр хадгалах байр руу илгээнэ.

6.4.8 Вакцин биобэлдмэлийг автоклавт халдваргүйжүүлж устгана. Шатаах арга ашиглаж байгаа бол шууд шатааж устгана. Вакцины савлагааг задлан халдваргүйжүүлэх уусмалд хийхийг хориглоно.

6.4.9 Устгасан вакцин биобэлдмэлийн хүн тун, тоо хэмжээг Вакцин биобэлдмэлийн зарцуулалтын маягтад бүртгэнэ. Их хэмжээгээр устгах тохиолдолд вакцин биобэлдмэлийн нэр, тоо, хэмжээ, хүн/тун цувралын дугаар, устгалын шалтгаан, устгасан арга, устгал хийсэн бүрэлдэхүүн зэрэг мэдээллийг тусгасан тэмдэглэл үйлдэнэ.

6.4.10 Зоонозын халдварын тандалт, оношилгоо, судалгаа, шинжилгээний үед үүссэн мал, амьтны сэг, зэм зэргийг төвлөрсөн байгууламжид устгах боломжгүй үед ЭМС-ын 2025 оны А/193 тоот тушаалын зургаадугаар хавсралтын дагуу устгана.

6.4.11 Аюултай хог хаягдлыг гэрээний дагуу тусгай зөвшөөрөлтэй төвлөрсөн байгууламжид устгуулахаар хүлээлгэн өгч анхан шатны бүртгэл маягтад тэмдэглэнэ.

6.5 Үйл ажиллагааны зураглал

Аюултай хог хаягдал устгах үйл ажиллагааны зураглалыг Хавсралт 2 харна уу.

Долоо. Албаны дарга, эмч, ажилтнуудын үүрэг, хариуцлага

7.1 Албаны даргын үүрэг

7.1.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг байгууллагын төсөвт тусгах саналыг хүргүүлнэ.

7.1.2 Хог хаягдлын менежментэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, дахин ашиглах, боловсруулах, зөвшөөрөгдсөн аргаар устгахад зарцуулагдах санхүүгийн тооцоо судалгааг хийж төсөвт тусгана.

7.1.3 Стандартад нийцсэн хог хаягдлын уут сав, аюулгүй хайрцаг ашиглах. Хог хаягдалтай харьцаж ажиллаж байгаа албан хаагчийг чанарын шаардлага хангасан хамгаалах хувцас хэрэглэлээр хангах талаар байгууллагын удирдлагад танилцуулна.

7.1.4 Хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажилтныг томилж ажиллуулах саналыг удирдлагын зөвлөлд хүргүүлнэ.

7.1.5 ЗӨСҮТ нь эм, эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах устгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тусгай зөвшөөрөлтэй төвлөрсөн байгууламжтай газар гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

7.1.6 Аюултай хог хаягдалтай холбоотой осол гэмтэл, эрсдэлт нөхцөл байдал үүссэн үед ХСХБАД-ийн баг, хөдөлмөр аюулгүй байдал, эрсдэл хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж хамтран ажиллана.

7.2 Ариутгагч, бэлдмэлчин нарын үүрэг

7.2.1 Хог хаягдлыг мөрдөгдөж буй, журам, заавар, эрх зүйг баримтлан ангилж хог хаягдал цуглуулах уут, саванд хийнэ.

7.2.2 Аюултай хог хаягдал цуглуулах уутыг хогийн саванд хийж огноо, лабораторийн нэрийг бичнэ.

7.2.3 Аюултай хог хаягдлыг цуглуулах, халдваргүйтгэлийн уусмалаас халдвартай материал гаргаж, жинлэн хог хаягдлын ажилтанд хүлээлгэн өгнө.

7.2.4 Химийн халдваргүйтгэлд хэрэглэх халдваргүйжүүлэх уусмалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж бэлтгэнэ.

7.2.5 Хэрэглэсэн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг угааж, цэвэрлэн, дараагийн үйлчилгээнд бэлэн байлгана.

7.2.6 Ажил үүрэгтэй холбоотой аливаа үл тохирлыг холбогдох албан тушаалтанд бичгээр мэдээлэх

7.3 Хог хаягдлын ажилтны үүрэг

7.3.1 Өдөр бүр аюултай хог хаягдлыг жинлэн хүлээн авч, анхан шатны бүртгэл маягтыг хөтөлнө.

7.3.2 Аюултай хог хаягдлын хаяглалт, цуглуулах явцад хяналт тавина.

7.3.3 Халдвартай хог хаягдлыг автоклаваар халдваргүйтгэн хог хаягдал түр хадгалах байранд байршуулна.

7.3.4 Хог хаягдлын жинг цэнэглэж бэлэн байдлыг хангана.

7.3.5 Аюултай хог хаягдал түр хадгалах өрөөг цэвэрлэх, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортонд ажилласан цагийг бүртгэнэ.

7.3.6 Элемент медикал ХХК-д дуудлага өгч аюултай хог хаягдлыг устгуулахаар хүлээлгэн өгч бүртгэл маягтыг хөтөлнө.

7.3.7 Хог хаягдлын анхан шатны бүртгэл маягтын мэдээ гаргана.

7.3.8 Хэрэглэсэн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг угааж, цэвэрлэн, дараагийн үйлчилгээнд бэлэн байлгана.

7.3.9 Ажил үүрэгтэй холбоотой аливаа үл тохирлыг холбогдох албан тушаалтанд бичгээр мэдээлнэ.

7.4 Халдвар судлагч эмчийн үүрэг

7.4.1 Аюултай хог хаягдал ангилан ялгах, цуглуулах, халдваргүйжүүлэх явцад хяналт тавина.

7.4.2 Үүсэж байгаа хог хаягдлын байдалд дүн шинжилгээ хийж аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах бодлого баримтлана.

7.4.3 Хог хаягдлын ажилтны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах чиглүүлэх, хог хаягдлын тайлан мэдээнүүдийг нэгтгэх, дүгнэх, хог хаягдлын менежментийн талаар бүх ажилчдад сургалт зохион байгуулах.

7.4.4 Илэрсэн үл тохирол (алдаа, зөрчил)-ыг шийдвэрлэж, цаашид авах арга хэмжээний талаар санал гаргана.

7.4.5 Хог хаягдлыг түр хадгалах байр руу зөөвөрлөх маршрут, ажлын цагийн хуваарийг гаргаж албаны даргаар батлуулсан байна.

7.4.6 ЗӨСҮТ болон ЗӨСТ-ийн нийт аюултай хог хаягдлын мэдээг нэгтгэн сар бүрийн 10-ны дотор ХӨСҮТ-ийн тандалт судалгааны албанд цахимаар хүргүүлнэ.

7.5 Эмч, ажилтан, лаборант нарын үүрэг

7.5.1 Хог хаягдлыг мөрдөгдөж буй журам, заавар, эрх зүйг баримтлан ангилж хог хаягдал цуглуулах уут, хогийн сав, аюулгүйн хайрцагт хийнэ.

7.5.2 Хогийн сав, аюулгүйн хайрцгийн $\frac{3}{4}$ хэмжээнээс хэтрүүлэхгүй хогийг хийнэ.

7.5.3 Химийн халдваргүйтгэл хийхдээ халдваргүйтгэл эхэлсэн болон дуусах хугацааг тавина.

7.5.4 Хог хаягдал холбогдох аливаа үл тохирлыг шуурхай мэдээлэх

7.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын эм зүйч, тооцооны нягтлан бодогч нарын үүрэг

7.6.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахад байгаа хугацаа дуусах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, эмнэлгийн зориулалттай бүтээгдэхүүний дотоод хяналтыг сайжруулж хугацаа болон хадгалалтын горимд олгогч-эм зүйч, захиалга хүлээн авагч-эм зүйч, чанарын менежер нар өдөр бүр хяналт тавих, тооцооны нягтлан бодогч комиссын бүрэлдэхүүнтэй улирал бүр тооллого хийж акт үйлдэн 6 сараас дээш дуусах хугацаа дөхсөн эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэж эрүүл мэндийн байгууллагад яаралтай түгээх арга хэмжээ авч ажиллах.

7.6.2 Төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахад байгаа хугацаа дууссан, хагарч гэмтсэн, гаж нөлөө илэрсэн, цувралд эмийг зах зээлд гаргасны дараа лабораторийн болон эмнэлзүйн туршилт судалгаагаар хүний бие махбодод сөрөг нөлөө үзүүлсэн нь нотлогдон тогтоогдож хэрэглэх боломжгүй болсон эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, эмнэлгийн зориулалттай бүтээгдэхүүнийг аюулгүй байдлыг ханган акталж устгах, бүртгэл тооцоог өдөр тутмын хяналт болон улирлын тооллогоор хадгалалт, хугацааны хяналтаар илрүүлэх. Байгууллагын удирдлагын тушаалаар 3 ба түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй комисс томилж тооллого хийнэ. Комиссын гишүүд тухайн барааны нэр төрөл, тун, савлалт, тоо ширхэг, үнэ, үйлдвэрлэгч дуусах хугацаа зэрэг мэдээллийг батгаасан акт үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулан нэг хувийг Эрүүл мэндийн яаманд, нэг хувийг төвийн захиралд, ерөнхий нягтлан бодогч нарт хүргүүлэх арга хэмжээ авна.

7.7 Эм, эмнэлгийн хэрэгсэл устгах, мэдээлэх үйл ажиллагаа

7.7.1 Эмийг хэлбэрээр нь буюу шингэн, шахмал, тосон түрхэц, ампул тус бүрээр ангилж ялгана.

7.7.2 Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, шингэн нэвчдэггүй, бат бөх хүрэн өнгийн уутанд хийж, савлан бусад төрлийн хог хаягдалтай холихгүй түр хадгална.

7.7.3 Аюултай хог хаягдлыг стандартаар тогтоосон "Био аюултай" тэмдэг, тэмдэглэгээтэй саванд хадгалах ба ил харагдахуйц газар тасаг нэгжийн нэр, хог хаягдал үүсэн огноо, тухайн хаягдлын нэрийг тэмдэглэсэн байна.

7.7.4 Хог хаягдлын асуудал хариуцсан ажилтанд дагалдах бичгийг хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.


7.7.5 Акталсан болон устгасан эм, хэрэгслийг агуулахын бүртгэлд тэмдэглэх.

7.7.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн устгалын мэдээ, тайланг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдээлэх.


Найм. Хариуцлага

8.1 Журмын заалтуудыг биелүүлээгүй болон зөрчсөн ажилтанд зохих хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, зоонозын өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааварт заасны дагуу арга хэмжээ авна.

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
НӨӨЦИЙН АГУУЛАХААС ГАРСАН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ**



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЛАБОРАТОРИОС ГАРСАН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУРАГЛАЛ (АХБҮА-Процессын зураг №2)



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН БҮРТГЭЛ МАЯГТ

1. Лабораторийн гарч байгаа аюултай хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/193 дүгээр “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах ” зааврын тавдугаар хавсралтын дагуу 1, 2, 4, 5 дугаарын анхан шатны бүртгэл маягтуудыг хөтөлнө.

2. Нөөцийн агуулахаас гарах эмийн хог хаягдлыг дараах бүртгэлийн дагуу бүртгэнэ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хог хаягдлыг хүлээлцсэн бүртгэл 09

Хүлээлгэн авсан байгууллага..... Хүлээн өгсөн байгууллага.....

Огноо

№	Эм, эмнэлгийн хэрэгслийн хог хаягдлын нэр	Үйлдвэрлэгч	Цувралын дугаар	Хэмжих нэгж (ш, кг, мл)	Тоо хэмжээ	Устгал хийх зөвшөөрлийн дугаар

Хаягдлыг хүлээлгэн өгсөн хүний албан тушаал: _____

Нэр _____ / _____ / Гарын үсэг _____

Холбоо барих утасны дугаар _____

Хаягдал хүлээн авч тээвэрлэсэн машины дугаар _____

Ажилтны нэр _____

Гарын үсэг _____